**УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Увс аймгийн Ойрад хөгжимт жүжгийн театрын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код:** УВА-2025/152/НА-СТА-ТШЗ

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br>Улаангом хот<br>2025 он | Увс аймаг дахь Төрийн аудитын газар,<br>Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь<br>Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn<br>Аудитын менежер: М.Бат-Амгалан<br>Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn<br>Аудитор: Б.Одгэрэл<br>Утас: 86032989, Цахим хаяг: Odgerelb@audit.gov.mn |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Ө.Бадрахын гудамж,
3 дугаар баг, Улаангом сум, Увс аймаг, 85165
Утас/Факс: 7045-3317
Цахим шуудан: uvs@audit.gov.mn

2025.02.25 № УВА-2025/152/НА-СТА-ТШ3

танай ____________ -ны № ________________-т

УВС АЙМГИЙН ОЙРАД ХӨГЖИМТ
ЖҮЖГИЙН ТЕАТРЫН ДАРГА
Б.ЛХАГВАСҮРЭН ТАНАА

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Увс аймгийн Ойрад хөгжимт жүжгийн театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Увс аймгийн Ойрад хөгжимт жүжгийн театрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Ойрад хөгжимт жүжгийн театр нь Соёлын сайдын 2024 оны 02 дугаар сарын 28-ны өдрийн А/50 дугаар тушаалаар 150,000.0 мянга, аймгийн Засаг даргын 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн А/109 дүгээр тушаалаар 100,000.0 мянга, нийт 250,000.0 мянган төгрөгийн санхүүжилтээр "Тэнгэрийн сэнтий" дуулалт бүжгэн жүжгийг туурвисан байна. Уг жүжгийг хүлээн авах комиссыг Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын 2024 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн тушаалаар томилсон болович хүлээн авах комисс ажиллаагүй байхад санхүүжилтийг бүрэн өгсөн, дээрх ажлын хүрээнд хөгжмийн мастер бичлэг хийгээгүй, дуу бичүүлээгүй, дууны мастеринг хийлгээгүй, бүжигчид, дуучид, жүжигчид, хөгжимчдийн хувцас, хэрэгсэл шаардлага хангахгүй, дутуу ирсэн зэрэг эрсдэлтэй асуудал нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6 дахь заалтад "төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх", Ойрад хөгжимт жүжгийн театрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчтэй байгуулсан 2024 оны 04 дүгээр сарын 16-ны өдрийн №02 дугаартай Тэнгэрийн сэнтий дуулалт жүжгийн хөгжмийн найруулга, микс, мастерингаар

85250ᑦᑦ5ᐟ0

ажиллах гэрээний 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт "... үлдэгдэл эцсийн тооцоог ... 30 хувь болох 5,700,000 төгрөгийг 2024 оны 07 дугаар сарын 16-ны өдрийн дотор хүлээлгэн өгч тооцоог дуусгана", гэж заасныг хэрэгжүүлэн ажиллаагүй нь нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

АДБОУС 2706.7-д тодорхойлсноор асуудлыг онцолсон хэсэгт санхүүгийн тайлангийн тухай хэрэглэгчдийн ойлголтыг бүрдүүлэхэд ач холбогдолтой, санхүүгийн тайланд толилуулсан, тодруулсан мэдээлэл байхгүй болно.

**Аудитын гол асуудал**

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

**Бусад асуудлын хэсэг**

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.БАТСУУРЬ

9065555 1525010041

# 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөг/

| ДАНС | Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 308,082,089.70 | 424,662,667.10 |
| 31 | МӨНГӨ БА ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ | 16,569,830.11 | 0.00 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 16,569,830.11 | 0.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 16,569,830.11 | 0.00 |
| 33 | АВЛАГА | 14,906,828.09 | 33,684,467.60 |
| 33100 | Ажиллагсадтай холбогдсон авлага | 0.00 | 2,064,931.32 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 14,140,600.00 | 29,220,600.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 766,228.09 | 2,398,936.28 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 276,605,431.50 | 390,978,199.50 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1 4,792,350.00 | 6,790,900.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 14,982.00 | 70,000.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 10,749,510.00 | 14,183,710.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 251,048,589.50 | 369,933,589.50 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 534,917,989.03 | 577,559,074.34 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 534,917,989.03 | 577,559,074.34 |
| 392 | Биет хөрөнгө | 226,157,826.07 | 269,340,161.66 |
| 39201 | Барилга, байгууламж | 183,003,778.44 | 183,003,778.44 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (14,226,719.28) | (18,134,653.50) |
| 39203 | Авто тээврийн хэрэгсэл | (132,840,000.00 | 132,840,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 132,840,000.00) | (132,840,000.00) |
| 39205 | Машин, тоног төхөөрөмж | 152,064,781.08 | 211,537,256.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (120,848,309.00) | (132,263,533.24) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 51,139,969.86 | 51,729,769.86 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (48,879,164.29) | (49,837,344.93) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 78,692,552.50 | 86,342,552.50 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (54,789,063.24) | (63,037,663.55) |
| 393 | Биет бус хөрөнгө | 308,760,162.96 | 308,218,912.68 |
| 39301 | Програм хангамж | 385,000.00 | 385,000.00 |
| 39302 | Хасагдуулга | (385,000.00) | (385,000.00) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 318,431,700.00 | 318,431,700.00 |
| 39304 | Хасагдуулга | (9,671,537.04) | (10,212,787.32) |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН** | **843,000,078.73** | **1,002,221,741.44** |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН | 1,760,000.00 | 1,807,000.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,760,000.00 | 1,807,000.00 |
| 413 | Өглөг | 1,760,000.00 | 1,807,000.00 |
| 4136 | Бусад өглөг | 1,760,000.00 | 1,807,000.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 0.00 | 47,000.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,760,000.00 | 1,760,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН | 841,240,078.73 | 1,000,414,741.44 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 841,240,078.73 | 1,000,414,741.44 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /ЗГСан/ орон нутгийн сан | 747,992,029.30 | 747,992,029.30 |
| 51101 | Өмч: -Төрийн өмч | 747,992,029.30 | 747,992,029.30 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | (197,344,698.81) | (38,170,036.10) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (197,344,698.81) | (197,344,698.81) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 0.00 | 159,174,662.71 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 290,592,748.24 | 290,592,748.24 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ДҮН** | **843,000,078.73** | **1,002,221,741.44** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөг/

| ДАНС | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,312,103,225.19 | 3,095,970,064.18 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 98,435,250.00 | 419,179,125.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 73,756,250.00 | 419,179,125.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 73,756,250.00 | 419,179,125.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 62,329,350.00 | 124,055,950.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 0.00 | 260,000,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 11,426,900.00 | 35,123,175.00 |
| 122 | Тусламжийн орлого | 24,679,000.00 | 0.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 24,679,000.00 | 0.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,213,667,975.19 | 2,676,790,939.18 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 14,000,000.00 | 0.00 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 14,000,000.00 | 0.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 87,112,600.00 | 96,731,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 87,112,600.00 | 96,731,200.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 2,112,555,375.19 | 2,580,059,739.18 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,112,555,375.19 | 2,580,059,739.18 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН (II) | 2,272,443,645.08 | 2,936,795,401.47 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,272,443,645.08 | 2,936,795,401.47 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,883,486,160.85 | 2,855,042,183.41 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,447,491,771.49 | 2,099,293,803.97 |
| 210101 | Цалин | 904,970,229.02 | 1,435,157,657.80 |
| 210102 | Нэмэгдэл цалин | 351,105,591.12 | 447,322,747.17 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 74,065,412.00 | 52,077,889.00 |
| 210104 | Урамшуулал | 117,350,539.35 | 164,735,510.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 182,618,425.69 | 261,794,758.22 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 128,020,506.41 | 181,734,916.90 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 13,394,958.61 | 19,565,034.54 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 9,703,166.39 | 10,311,551.90 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 4,429,345.42 | 9,376,823.11 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 27,070,448.86 | 40,806,431.77 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 80,561,701.77 | 88,851,221.37 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,807,661.77 | 6,391,911.46 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 75,185,929.00 | 81,117,967.91 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 568,111.00 | 1,341,342.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 33,305,298.19 | 53,063,010.16 |
| 210401 | Бичиг хэргийн материал | 3,280,328.00 | 4,586,482.00 |
| 210402 | Тээвэр, шатахууны зардал | 22,817,150.00 | 38,543,845.00 |
| 210403 | Шуудан холбоо интернетийн төлбөр | 1,600,270.19 | 1,412,583.16 |
| 210405 | Хог хаягдал устгах, цэвэрлэх | 240,000.00 | 398,000.00 |
| 210406 | Бага үнэ түргэн элэгдэл зүйлс | 5,367,550.00 | 8,122,100.00 |
| 2105 | Нормативт зардал | 390,000.00 | 0.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 390,000.00 | 0.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 4,515,300.00 | 5,085,000.00 |
| 210601 | Багаж хэрэгсэл | 1,449,800.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,065,500.00 | 5,085,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 40,626,550.00 | 45,062,000.00 |
| 210701 | Гадаад томилолтын зардал | 5,760,000.00 | 0.00 |
| 210702 | Дотоод томилолтын зардал | 34,866,550.00 | 45,062,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 55,506,620.20 | 204,631,250.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 51,009,020.20 | 198,267,650.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 720,000.00 | 720,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 271,000.00 | 260,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 132,000.00 | 179,000.00 |
| 210806 | Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс | 323,000.00 | 2,153,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,051,600.00 | 3,051,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 38,470,493.51 | 97,261,139.69 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 13,873,500.00 | 69,767,950.00 |
| 210902 | Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал | 1,316,000.00 | 2,422,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 23,280,993.51 | 25,071,189.69 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 388,957,484.23 | 81,753,218.06 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 385,472,086.00 | 58,444,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 7,514,800.00 | 8,660,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 75,674,280.00 | 0.00 |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 298,818,006.00 | 37,952,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 3,465,000.00 | 11,832,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 0.00 | 19,014,239.43 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 0.00 | 19,014,239.43 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,485,398.23 | 4,294,978.63 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,485,398.23 | 4,294,978.63 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III=I-II) | 39,659,580.11 | 159,174,662.71 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (VII=III+VI) | 39,659,580.11 | 159,174,662.71 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөг/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I) | 2,305,066,325.19 | 3,060,966,889.18 |
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 91,398,350.00 | 384,175,950.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 66,719,350.00 | 384,175,950.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 66,719,350.00 | 384,175,950.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 66,719,350.00 | 124,175,950.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 260,000,000.00 |
| 122 | Тусламжийн орлого | 24,679,000.00 | - |
| 122005 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 24,679,000.00 | - |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,213,667,975.19 | 2,676,790,939.18 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 14,000,000.00 | - |
| 131103 | ЗГНХ, ЗДНХөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөнөөс | 14,000,000.00 | - |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 87,112,600.00 | 96,731,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 87,112,600.00 | 96,731,200.00 |
| 1330 | Төсвийн захирагчдаас | 2,112,555,375.19 | 2,580,059,739.18 |
| 133001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,112,555,375.19 | 2,580,059,739.18 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II) | 2,260,747,602.46 | 3,077,536,719.29 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 2,260,747,602.46 | 3,077,536,719.29 |
| 210 | БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 1,871,140,118.23 | 2,999,863,501.23 |
| 2101 | Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил | 1,447,998,363.27 | 2,099,874,301.70 |
| 210101 | Үндсэн цалин | 911,250,679.68 | 1,278,330,552.04 |
| 210102 | Нэмэгдэл | 326,553,339.50 | 578,197,649.66 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 76,439,035.62 | 77,420,000.00 |
| 210104 | Үр дүнгийн урамшуулал | 133,755,308.47 | 165,926,100.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 181,208,500.00 | 264,631,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгалын шимтгэл | 123,280,900.00 | 179,949,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгалын шимтгэл | 14,482,100.00 | 21,170,600.00 |
| 210203 | ҮОМШ өвчний даатгалын шимтгэл | 11,585,500.00 | 10,663,006.14 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгалын шимтгэл | 2,896,400.00 | 10,507,593.86 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгалын хураамж | 28,963,600.00 | 42,341,100.00 |
| 2103 | Байр ашиглалтай холбоотой тогтмол зардал | 80,561,701.77 | 88,851,221.37 |
| 210301 | Гэрэл цахилгааны зардал | 4,807,661.77 | 6,391,911.46 |
| 210302 | Түлш, халаалтын зардал | 75,185,929.00 | 81,117,967.91 |
| 210303 | Цэвэр, бохир усны зардал | 568,111.00 | 1,341,342.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 33,618,193.19 | 56,003,378.16 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,965,810.00 | 4,546,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 23,067,150.00 | 38,543,845.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,714,383.19 | 1,412,583.16 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 540,000.00 | 398,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,330,850.00 | 11,102,750.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,105,460.00 | 58,569,000.00 |
| 210601 | Багаж техник хэрэгсэл | 3,039,960.00 | 52,894,200.00 |
| 210602 | Тавилга | - | 589,800.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210604 | Урсгал засвар | 3,065,500.00 | 5,085,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 40,476,550.00 | 37,040,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 40,476,550.00 | 37,040,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 59,695,150.00 | 226,819,100.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр хураамж | 55,197,550.00 | 220,042,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 720,000.00 | 1,000,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 271,000.00 | 180,000.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 132,000.00 | 212,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 323,000.00 | 2,333,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,051,600.00 | 3,051,600.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 21,476,200.00 | 168,074,600.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,160,200.00 | 165,652,600.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,316,000.00 | 2,422,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 389,607,484.23 | 77,673,218.06 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 386,122,086.00 | 54,364,000.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 7,514,800.00 | 8,660,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 75,674,280.00 | - |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 298,818,006.00 | 37,952,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал | 4,115,000.00 | 7,752,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 19,014,239.43 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 19,014,239.43 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 3,485,398.23 | 4,294,978.63 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 3,485,398.23 | 4,294,978.63 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II) | 44,318,722.73 | (16,569,830.11) |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V) | 27,879,600.00 | - |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 27,879,600.00 | - |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 27,879,600.00 | - |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 27,879,600.00 | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V) | (27,879,600.00) | - |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 16,439,122.73 | (16,569,830.11) |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 130,707.38 | 16,569,830.11 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 16,569,830.11 | 0.00 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөг/

| | ҮЗҮҮЛЭЛТ | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан үр дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | 2023 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл | 442,274,425.15 | 141,209,632.40 | (280,548,577.96) | 302,935,479.59 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 442,274,425.15 | 141,209,632.40 | (280,548,577.96) | 302,935,479.59 |
| C07 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | (6,621,601.27) | (6,621,601.27) |
| C09 | 2023 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 747,992,029.30 | 290,592,748.24 | (197,344,698.81) | 841,240,078.73 |
| D01 | 2024 оны 01-р сарын 01-ээрх үлдэгдэл | 747,992,029.30 | 290,592,748.24 | (197,344,698.81) | 841,240,078.73 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 747,992,029.30 | 290,592,748.24 | (197,344,698.81) | 841,240,078.73 |
| D08 | Тайлант үеийн үр дүн /Цэвэр ашиг алдагдал/ | - | - | 159,174,662.71 | 159,174,662.71 |
| D09 | 2024 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл | 747,992,029.30 | 290,592,748.24 | (38,170,036.10) | 1,000,414,741.44 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөг/

| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү |
|---|---|---|---|---|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 16,569,830.11 | (16,569,830.11) |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,066,425,300.00 | 3,054,227,501.23 | 12,197,798.77 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | 3,066,425,300.00 | 3,054,227,501.23 | 12,197,798.77 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | 3,011,037,000.00 | 2,999,863,501.23 | 11,173,498.77 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,101,554,700.00 | 2,099,874,301.70 | 1,680,398.30 |
| 210101 | Үндсэн цалин | 1,257,504,000.00 | 1,278,330,552.04 | (20,826,552.04) |
| 210102 | Нэмэгдэл | 608,856,200.00 | 578,197,649.66 | 30,658,550.34 |
| 210103 | Унаа, болон бусад нөхөн олговор | 77,520,000.00 | 77,420,000.00 | 100,000.00 |
| 210104 | Урамшуулал | 157,674,500.00 | 165,926,100.00 | (8,251,600.00) |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 264,631,900.00 | 264,631,900.00 | 0.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 179,949,600.00 | 179,949,600.00 | 0.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 21,170,600.00 | 21,170,600.00 | 0.00 |
| 210203 | ҮОМШӨ ний даатгал | 10,585,300.00 | 10,663,006.14 | (77,706.14) |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 10,585,300.00 | 10,507,593.86 | 77,706.14 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 42,341,100.00 | 42,341,100.00 | 0.00) |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 93,145,400.00 | 88,851,221.37 | 4,294,178.63 |
| 210301 | Гэрэл цахилгаан | 5,179,600.00 | 6,391,911.46 | (1,212,311.46) |
| 210302 | Түлш, халаалт | 81,118,000.00 | 81,117,967.91 | 32.09 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,847,800.00 | 1,341,342.00 | 5,506,458.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 60,226,000.00 | 56,003,378.16 | 4,222,621.84 |
| 210401 | Бичиг хэрэг | 7,200,000.00 | 4,546,200.00 | 2,653,800.00 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | 43,686,000.00 | 38,543,845.00 | 5,142,155.00 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 900,000.00 | 1,412,583.16 | (512,583.16) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 240,000.00 | 398,000.00 | (158,000.00) |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 8,200,000.00 | 11,102,750.00 | (2,902,750.00) |
| 2106 | Эд хогшил худалдан авах | 58,569,800.00 | 58,569,000.00 | 800.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 52,894,200.00 | 52,894,200.00 | - |
| 210602 | Тавилга | 589,800.00 | 589,800.00 | - |
| 210604 | Урсгал засвар | 5,085,800.00 | 5,085,000.00 | 800.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 37,049,600.00 | 37,040,000.00 | 9,600.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 37,049,600.00 | 37,040,000.00 | 9,600.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | 226,906,100.00 | 226,819,100.00 | 87,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 220,042,500.00 | 220,042,500.00 | - |
| 210802 | Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал | 1,000,000.00 | 1,000,000.00 | - |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 180,000.00 | 180,000.00 | - |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 212,000.00 | 212,000.00 | - |
| 210806 | Мэдээллийн технологийн зардал | 2,420,000.00 | 2,333,000.00 | 87,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 3,051,600.00 | 3,051,600.00 | - |
| 2201 | Бараа үйлчилгээний бусад зардал | 168,953,500.00 | 168,074,600.00 | 878,900.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 165,653,500.00 | 165,652,600.00 | 900.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,300,000.00 | 2,422,000.00 | 878,000.00 |
| | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 55,388,300.00 | 54,364,000.00 | 1,024,300.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 55,388,300.00 | 54,364,000.00 | 1,024,300.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 8,660,300.00 | 8,660,000.00 | 300.00 |
| 213208 | Хөдөө ОН-т тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж | 38,976,000.00 | 37,952,000.00 | 1,024,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 7,752,000.00 | 7,752,000.00 | - |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,066,425,239.18 | 3,038,617,517.36 | 28,767,568.06 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,580,059,739.18 | 2,562,005,345.99 | 19,014,239.43 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 2,580,059,739.18 | 2,562,005,345.99 | 19,014,239.43 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 96,731,200.00 | 92,436,221.37 | 4,294,978.63 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 96,731,200.00 | 92,436,221.37 | 4,294,978.63 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 289,634,300.00 | 384,175,950.00 | (94,541,650.00) |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 129,634,300.00 | 124,175,950.00 | 5,458,350.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 160,000,000.00 | 260,000,000.00 | (100,000,000.00) |
| 122 | ТУСЛАМЖИЙН ЭХ ҮҮСВЭРЭЭС САНХҮҮЖИХ | 100,000,000.00 | - | 100,000,000.00 |
| 122005 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 100,000,000.00 | - | 100,000,000.00 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | 16,569,830.11 | (16,569,830.11) |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | 0.00 | (0.00) |
| 6 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ | | | |
| 61 | БАЙГУУЛЛАГЫН ТОО | 1.00 | 1.00 | - |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 76.00 | 76.00 | - |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | - |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 68.00 | 68.00 | - |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 7.00 | 7.00 | - |

## Гурав. Аудитын илрүүлэлт:

Аудитаар нийт 818,134.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс 504,434.5 мянган төгрөгийн алдааг залруулж, 313,699.5 мянган төгрөгийн зөрчил зөвлөмж өглөө.

### *5.1 <u>Залруулсан алдаа:</u>*

Ойрад хөгжимт жүжгийн театр нь санхүүгийн үр дүнгийн тайланд бараа үйлчилгээний зардлыг 6,089.0 мянга, бага үнэтэй түргэн элэгдэх зардлыг 610.0 мянга, гэрэл цахилгааны зардлыг 20,693.2 мянга, бичиг хэргийн зардлыг 3,133.6 мянган төгрөгөөр тус тус илүү, харин ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 441.7 мянга, түлш халаалтын зардлыг 20,279.5 мянга, цэвэр бохир усны зардлыг 413.7 мянга, тээвэр шатахууны зардлыг 2,500.0 мянга, шуудан холбооны зардлыг 633.6 мянга, дотоод томилолтын зардлыг 8,022.0 мянга, нэг удаагийн тэтгэмж шагнал урамшууллын зардлыг 3,717.0 мянга, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 34.9 мянга, үндсэн үйл ажиллагааны орлогыг 16,460.0 мянга, туслах үйл ажиллагааны орлогыг 100,000.0 мянга, урсгал үйл ажиллагааны санхүүжилтийг 321,406.3 мянган төгрөгөөр тус тус дутуу тайлагнасан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална”: 5.1.3 дахь заалтад “жинхэнэ хэрэгжилтийн”, 5.1.4 дэх заалтад “үнэн зөв байх” гэж заасантай нийцэхгүй, Үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байсан тул нийт 504,434.5 мянган төгрөгийн 16 алдаанд залруулга хийлгэлээ.

### 5.2 <u>Зөвлөмж</u>

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт:</u>***

Ойрад хөгжимт жүжгийн театр нь 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий 43,065.0 мянган төгрөгийн орлогын 8 гүйлгээ, 269,815.9 мянган төгрөгийн хөрөнгө зарцуулах 24 шийдвэрийг шилэн дансны цахим хуудаст байршуулаагүй байна.

***<u>Өгсөн зөвлөмж-1:</u>***

Цаашид Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмыг хэрэгжүүлэн ажиллах.

***<u>Илрүүлэлт:</u>***

Санхүүгийн тайлангийн аудитаар “Өөрчлөлтгүй” санал дүгнэлт авсан гэж нягтлан бодогчид 2 сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгож “Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “”Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.3-д “Мөнгөн шагналыг төрийн онцгой чухал буюу онц төвөгтэй албан даалгавар биелүүлсэн, төрийн байгууллагын үйл ажиллагаа, төрийн үйлчилгээг сайжруулах чиглэлээр шинэ санал, санаачилга гаргаж хэрэглээнд нэвтрүүлсэн төрийн албан хаагчид олгож болно” Байгууллагын удирдлагын шийдвэрээр тухайн ажилтныг шагнах мөнгөн шагналын хэмжээ нь сарын үндсэн цалинг 1.5 дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хүртэл хэмжээтэй байна” гэж заасныг 818.6 мянган төгрөгөөр хэтрүүлэн олгосон байна.

***<u>Өгсөн зөвлөмж-2:</u>***

Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ын 3.3 дахь заалтыг мөрдөж ажиллах.